

2023 оны 10 сарын 30 өдөр

№.....23/238

Төв аймаг Сэргэлэн сум

**“ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН”
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ**

“Тайлан хүргүүлэх тухай”

Манай үйлдвэр нь 2015 оноос Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт Евро блок нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэн ажиллаж байна.

Үйлдвэр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангахаар БОАЖЯ-н сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан журмын дагуу 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан хүргүүлж байгааг хүлээн авч дүгнэж өгнө үү.

Хавсралт: Тайлан, шаардлагатай материалууд

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.БАДАМДАМДИН

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ОРШИХ “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-НИЙ ЕВРО БЛОК
ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хянасан:

“ БОАЖЯ –ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

П. Шинэцэцэг

“Төв аймгийн БОАЖГ”-ын ахлах мэргэжилтэн

С. Эрдэнэцогт

Хэрэгжилтийг тайлагнасан:

“Монголын алт” (МАК) ХХК
“Евро блок үйлдвэр” -ийн дарга

Д. Бадамдамдин

Боловсруулсан:

“Монголын алт” МАК (ХХК)-ийн
“ Евро блок үйлдвэр” -ийн Байгаль орчны мэргэжилтэн

Б. Дашням

2023 он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	10
1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	13
2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ 	33
4 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	35
5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	35
6 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	35
7 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	35
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	39
9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ.....	41
10 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	45
11 ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	46
12 ДҮГНЭЛТ.....	47
ХАВСРАЛТМАТЕРИАЛУД.....	48

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУЛГА

Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Товч танилцуулга

Үйлдвэрийн нэр: МАК Евро блок үйлдвэр

Ангилал: Дэд бүтцийн хөгжил

Үйлдвэр эзэмшигчийн нэр: “Монголын Алт” (МАК) ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011071054

Хаяг: Регистрийн дугаар: 2095025


Хан-Уул дүүрэг, 1-р хороо, XIX хороолол, Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК) ХХК-ийн төв байр-44

Утас: 75759700, факс: 70107481

Хүснэгт 1: Эдэлбэр газрын эргэлтийн цэгүүд

№	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)	Цэг	Зай, м
11 га талбай				
1	107° 12' 40.4 //	47° 41' 46.79//	1-2	598.35
2	107° 12' 30.49 //	47° 42' 4.96//	2-3	145.74
3	107° 12' 37.00//	47° 42' 6.5//	3-4	557.41
4	107° 12' 50.19 //	47° 41' 50.78//	4-1	238.42
1 га талбай				
1	107° 12' 50.8 //	47° 41' 51.01//	1-2	156.51
2	107° 12' 47.19 //	47° 41' 55.45//	2-3	61.34
3	107° 12' 49.81//	47° 41' 56.34//	3-4	149.12
4	107° 12' 53.6 //	47° 41' 52.25//	4-1	69.88

Үйлдвэрийн байршил: Төв аймгийн Сэргэлэн сум 1-р багт Улаанбаатар хотоос зүүн урагш 40 км зайд, төмөр замын Баян зөрлөгийн дэргэд тус сумын Засаг Даргын 2011 оны 02-р сарын 16-ны өдрийн 19 тоот шийдвэрээр бетоны үйлдвэрлэлийн зориулалтаар 11 га, 2014 оны 06 сарын 13-ны өдрийн 129 тоот шийдвэрээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 1 га, нийт 12 га талбайг эзэмшиж байна.



Зураг: 1 Талбайн байрлал /google earth/

Үйлдвэрийн хүчин чадал

“Монголын алт” (МАК) ХХК нь “Евро блок үйлдвэр”-т Германы HESS группээс хоногт 900м^3 (цаашид хоногт 1550м^3 болтол өргөтгөх боломжтой) блок үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулсан.

Үйлдвэрийн шугам	КВТ 900
Хоногт ажиллах ээлжийн тоо:	2
Ээлжийн ажиллах хугацаа:	12 цаг
Автоклавын циклийн хугацаа:	12 цаг
Жилд ажиллах өдрийн тоо:	300 өдөр
Жилийн хүчин чадал:	$270\,000\text{ м}^3$



Зураг: 2 Евро блок үйлдвэрийн харагдах байдал

Ажиллах хүч:


Үйлдвэрийн бүтэц, орон тоо 249 ажилтантай байхаар ба одоогийн байдлаар 210 орчим хүн өдөр, шөнийн ээлжинд 165 орчин ажилтан ажиллана. Ээлжийн мастер, тоног төхөөрөмжийн оператор, засварчин, тогооч, угаагч, үйлчлэгч гэх мэт тасралтгүй үргэлжилсэн ажилтай хүмүүсийг солигдох ээлжтэй буюу амралттайгаар инженер техникийн ажилчид болон удирдлагууд солигдох ээлжгүйгээр ажиллана.

Технологийн үйл ажиллагааны үндсэн зарчим: Евро блок үйлдвэрлэх технологи нь манай оронд байгаа адил төрлийн технологитой харьцуулахад дараах давуу талуудтай. Үүнд:

1. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүчин чадлыг өргөтгөх боломжтой.

2. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээний хэлбэлзлийн хүлцэх алдаа бага (± 1.5 мм-ээс ихгүй), нарийвчлал өндөр.
3. Олон улсын болон европын стандартчиллын холбоо (CEM, EN)-ны шаардлагын төвшинд хүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.
4. Бүтээгдэхүүний сав баглаа, боодлыг олон улсын шаардлагын хэмжээнд шийдвэрлэсэн.
5. Бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, зүсэх ажиллагааны технологийн зохицолдолгооны шийдэл сайтай.
6. Даацын арматуртай эдлэхүүн үйлдвэрлэх, барилгын даац, дулаан тусгаарлалтын бүх бүтээц, элементийг үйлдвэрлэх шинэ шугамыг 2018 оны 4 сард ашиглалтанд оруулсан.

Схем: 1 Үйлдвэрийн технологи



Төслийн тоног төхөөрөмж, техник болон дэд бүтэц

Тоног төхөөрөмж: Германы HESS группээс хоногт 900м³ (цаашид хоногт 1550м³ болтол өргөтгөх боломжтой) Евро блок үйлдвэрлэх КВТ 900 үйлдвэрийн шугамыг суурилуулсан.

Цахилгаан, хангамж: Үйлдвэрийн цахилгааны суурилагдсан хүчин чадал 3.2МВт, үйлдвэрийн хүчдэл 400+5% VAC, 3 фаз + PE, 50Гц ±5%.

Хүснэгт: 2 Цахилгааны хэрэглээ

Цахилгааны хэрэглээ, кВт*Ц	1 м ³ Хийт бетонд	Жилийн хэрэглээ кВт-900
	19.5	7680000

Үйлдвэрээс 16.6км зайд байрлах Налайхын дэд станцаас 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татан үйлдвэрт шаардлагатай цахилгааны хэрэглээг хангаж байна



Зураг 3: Цахилгааны 35/0,4 кВ-ын дэд станц

Зам тээвэр: Улаанбаатар хотоос 45 км, Налайх дүүргээс 10 км зайтай Улаанбаатар – Замын үүд чиглэлийн олон улсын чанартай автозамаас 700 метр авто замаар явж хүрнэ.

Үйлдвэрийн түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нөхцөлийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3: Тээвэрлэлтийн нөхцөл

Материал	Хэмж их нэгж	Зай,км	Тээврийн хэрэгсэл	Тээвэрлэх хэмжээ		Тайлбар
				Хоногт	7 хоногт	
Элс	тн	35	Авто машин	15	102	Дэнжийн элсний орд, Налайх
Шохой	тн	280	Галттэрэг	1	7	МАК-ын цементийн үйлдвэр, 25-р зөрлөг

Цемент	тн	280	Галт тэрэг	2	12	МАК-ын шохойн үйлдвэр, 25-р зөрлөг
Гөлтгөнө	тн	280	Галт тэрэг, автомашин	0	2	Ширээгийн хөндийн гөлтгөнийн орд, 25-р зөрлөг
Нүүрс	тн	10, 450	Галт тэрэг, автомашин	37,1тн 12,8	4 вагон 90тн	Хөөтийн уурхай

Төслийн түүхий эд, туслах материал, эцсийн бүтээгдэхүүн

Байгалийн гаралтай түүхий эд:

Манай үйлдвэрийн үйл ажиллагаанд байгалийн баялгаас ус, элс хэрэглэгдэнэ.

Элс: Налайх дүүрэгт байрлах Дэнжийн элс-1 ордоос автомашинаар тээвэрлэн ирсэн элсийг үйлдвэр доторх агуулахад хадгалах ба шанагат ачигчаар элс түр хадгалах бункерт өгч туузан дамжуулагчаар дамжуулан бөмбөлөгт тээрэмд ачаална.

Шохой: Евро блок үйлдвэр хоногт 62 тн шохой хэрэглэх бөгөөд шохойг Хөтөл ХК-ийн шохойн үйлдвэрээс галт тэргээр тээвэрлэнэ. Галт тэргээр хүлээн авсан шохойг ус чийгээс хамгаалсан битүүмжлэлтэй агуулахад хадгалах бөгөөд технологийн шохойг урьдчилан буталсны дараа бөмбөлөгт тээрэмд тээрэмдэж зохих хувийн гадаргуутай болтол нунтаглан ажлын силост хадгална. Шохой гадаа буулгах талбайд битүү агуулах хийгдэж дууссан.



Зураг :4 Шохой хадгалах битүү агуулах

Гөлтгөнө: Евро блок үйлдвэр хоногт 19 тн гөлтгөнө хэрэглэх бөгөөд үйлдвэрт шаардлагатай гөлтгөнийг МАК-ын цементийн үйлдвэрээс галт тэргээр болон автомашинаар тээвэрлэнэ гэж тооцвол 7 хоногт 2 вагон гөлтгөнө хэрэглэнэ. Галт тэргэнээс хүлээн авсан гөлтгөнийг задгай агуулахад хадгалах бөгөөд 5мм-ээс жижиг ширхэгтэй болтол урьдчилан буталж тугнасны дараа бөмбөлөгт тээрэмд элстэй хамт өгч нунтаглана.



Зураг: 5 Гөлтгөнө хадгалах задгай талбай

Нүүрс: Хөөтийн уурхайн нүүрсийг хэрэглэх бөгөөд нүүрсний илчлэг 3400-3500 ккал/кг, ба чийглэг 8.5%, үнслэг 10-33.3%, дэгдэмхий бодисын агуулга 22.0-34.1% байна. 1 өдрийн хугацаанд нүүрсний зарцуулалт өдөрт 6 тонн 1 сарын хугацаанд 180 тн байна.

Ус: Евро блок үйлдвэрлэхэд хэрэглэх ус нь ямар нэгэн хортой хольц агуулаагүй рН нь 7-8.3 байна.

Бусад түүхий эд

Бусад түүхий эдэд цемент, хөнгөн цагааны нунтаг орно.


Цемент: Евро блок үйлдвэр хоногт 89 тонн цемент хэрэглэх бөгөөд цементийг МАК-ийн цементийн үйлдвэрээс галт тэргээр тээвэрлэнэ. Галт тэргээр хүлээн авсан задгай цементийг хийн тээврийн төхөөрөмжөөр буулган цементийн силост (агуулахад) хадгална. Цементийн силосоос ажлын силос руу хийн тээврээр тээвэрлэн тугнаж хэрэглэнэ.



Зураг: 6 Цемент буулгах хэсэг болон хадгалах силос

Хөнгөн цагааны нунтаг: Үйлдвэр нь жилд 80 тн хөнгөн цагааны нунтагийг худалдан авч тусгай агуулахад хадгалдаг бөгөөд агуулахыг “MNS 6458:2014 Химийн хорт бодис бүтээгдэхүүний агуулах, ерөнхий шаардлага”-д нийцүүлэн байгуулсан. Тус агуулахад

зөвхөн мэргэшсэн ажилтан орох зөвшөөрөлтэй бөгөөд нунтаг хөнгөн цагаан нь битүү дамжуулгаар зөөгдөн түүхий эдийн хольц бэлтгэх хэсэгт өгөгддөг.



Зураг:7 Химийн бодис ашиглах зөвшөөрөл



Зураг:8 Агуулах

Эцсийн бүтээгдэхүүн:

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэр” нь хоногт 292 тн элс, 62 тн шохой, 89 тн цемент, 18 тн гөлтгөнөөр 900м³ бетон үйлдвэрлэнэ.

Хүснэгт:4 Түүхий эдийн хэрэглээ

Түүхий эд материалын нэр	Хэмжих нэгж	Хэрэглээ	
		Хоногт	7 хоногт
Элс	тн	292.0	2044
Шохой	тн	62.0	434
Цемент	тн	89.0	693
Гөлтгөнө	тн	18.0	126
Хийт бетон,	м ³	900	6300



Зураг:9 Бэлэн бүтээгдэхүүн

Нэгдсэн менежментийн тогтолцоо: Манай үйлдвэр нь 2022 оны 12 сарын 30 нд **ISO 9001:2015** “Чанарын менежментийн тогтолцоо”, **ISO 45001:2018** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо”, **ISO 14001:2015** Байгаль орчны менежментийн тогтолцоо олон улсын стандартуудын аудитаа амжилттай хамгаалж баталгаажуулалтын гэрчилгээг гардан авч нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг:10 Нэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ

1.1 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Евро блок үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг 2021 оны БОННУ-ний нэмэлт тодотголоор дараах байдлаар тодорхойлсон байдаг. Байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал. Төсөл хэрэгжих явцад байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг.

Хүснэгт: 5 Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Бохирдол, нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэл /үйл ажиллагаа/	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
1	2	3	4
Нэг. Орчин			
1.1	Тоосжилт	Түүхий эдийг тээвэрлэх зөөх, үйлдвэрийн бутлах,тээрэмдэх хэсэг	Үйлдвэрийн гадна болон доторх агаар орчинд тархах, ажилчдын эрүүл мэндийн байдалд нөлөөлнө.
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, угаар	Тээвэрлэлтэнд хэрэглэгдэх машин, механизм	Агаар орчинд тархах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр. Усан орчин			
2.1	Хатуу болон шингэн хаягдал	Ахуйн болон шатах тослох материалын хаягдал Тээвэрлэлтийн явцад техникийн бүрэн бус байдал, хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих	Хур борооны усаар угаагдаж хөрс, гүний ус бохирдуулна
Гурав. Хөрс			
3.1	Эвдрэл	Цементийн агуулахын барилга барих, засвар шинэчлэл хийх үед суурь ухах хөрс эвдэгдэх, овоолгод дарагдах, дагтарших, талхлагдах	Хөрсний физик механик шинж чанарт өөрчлөлт орж болно. Барилгын ажлын дараа нөхөн сэргээх боломжтой
3.2	Бохирдол	Шатах тослох материалын болон ахуйн хог хаягдал	Бохирдлоос сэргийлэх, нөхөн сэргээх боломжтой Хэмжээ хязгаарлагдмал Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанарт өөрчлөлт орж болно. Шавьж хорхой байршлаа сэлгэх, хордох, үхэж үрэгдэж болно.
Дөрөв. Ургамал бүрхэвч			
4.1	Газар шорооны ажлын үед	Ургамлан бүрхэвч бүхэлдээ устгагдах, дарагдах байдлаар үгүй болно.	Хэмжээ хязгаарлагдмал Төрөл, зүйл устаж, өөрчлөгдөж болно.
4.2	Хордолт	Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал	Хэмжээ хязгаарлагдмал Ургамал эргэлт буцалтгүй устаж болно. Удамшил генд өөрчлөлт орж болно.
4.3	Талхлагдах	Хүний хөл, үйл ажиллагаанд байнга өртөж буй зөрөг зам, жим, талбай ашиглалтын орчин	Биомассын хэмжээ багасна Төрөл зүйл устаж болно. Нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
Тав. Нийгэм эдийн засгийн орчин			

5.1	Эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх	Орчин үеийн чанарын шаардлага хангасан, дэвшилтэт технологи бүхий барилгын материалаар зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах
5.2	Шинээр ажиллагсад авна	Эдийн засгийн чадавх дээшилнэ. Ажлын байр шинээр бий болно.	Тогтмол

Төсөл хэрэгжих явцад байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр,эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг.

Хүснэгт: 6

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Үргэлжлэх хугацаа				Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Урт хугацааны	Богино	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал										
Гүний усны нөөцөд нөлөө үзүүлэх	x			x						x
Хөрс, ургамлын талхагдал	x				x				x	
Агаарын орчинд нөлөөлөх	x				x			x		
Хээрийн түймрийн аюулд өртөх	x				x			x		
Тоосонцорын бохирдол	x				x				x	
2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал										
Үйлдвэрийн ажиллагаанд хэрэглэх химийн бодис, тос тослох материалууд хөрсөнд үзүүлэх нөлөө	x			x					x	
Машин механизмын үйлчлэлээр байгаль орчин нөлөөлөх нөлөөлөл	x				x				x	
Усан орчинд үзүүлэх нөлөө /гүний/	x			x						x
Төслийн үйл ажиллагаанаасүүсгэх дуу шуугианы нөлөө	x				x				x	
Тоосонцроос үзүүлэх нөлөө	x				x				x	
Дулааны хэрэглээнээс үзүүлэх нөлөө /уурын зуух/	x						x		x	
3. Байгалийн нөөц ашиглалт										
Гүний ус		x			x				x	
Элс	x				x					x
Гөлтгөнө	x				x					x
Нүүрс	x				x				x	

Хур тунадсаар хуримтлагдах усны хэрэглээ		x			x					x
Хөрсний үржил		x					x			x
4. Байгаль орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ /гүний/		x								x
Хөрсний элэгдэл, бохирдол	x			x					x	
Агаарын бохирдол	x						x		x	
Ургамлын төрөл зүйлийн устгал	x			x					x	
5. Нийгэм эдийн засгийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого нэмэгдэх	x				x				x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x				x	
Ажлын байр нэмэгдэх	x			x					x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x					x
6. Бусад асуудал										
Хөрсөнд үзүүлэх туслах материалын нөлөө	x				x			x		
Чимээ шуугианы нөлөө		x			x					x
Болгоомжгүйгээс гал түймэр гарах		x			x			x		
Хүчтэй буюу аадар борооны улмаас үер болох	x				x			x		
Хатуу, шингэн хог хаягдал ихсэх	x			x						x
Химийн бодис болон нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт муугаас хөрс, ус бохирдох	x			x					x	
Дүн	25	6	-	8	19	-	3-	5	16	10

Тайлбар: x-болзошгүй нөлөөлөл, бөглөгдөөгүй нь тухайн төсөлд хамааралгүй.

1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Үйлдвэр нь 2023 онд 271,331 м³ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. .

Үүнд:

- Монгол улсын Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах.
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах.
- Ногоон байгууламжийг 20%-р нэмэгдүүлж 2000м² талбайг зүлэгжүүлэх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 200 мод тарих.
- Нийт ажилчдад байгаль орчны талаар мэдээллээр хангах, сургалт орох.

- Хог хаягдлын менежментийн журмын хэрэгжилтийг сайжруулж гүйцэтгэлийг 90.85%-д хүргэх.
- Аюултай хог хаягдлын хадгалалт болон хогийн цэгийг сайжруулах тогтмол хяналт тавих.
- Конденсацийн усыг дахин ашиглах судалгаа, туршилт хийж дахин ус ашиглалтыг 15%- иар нэмэгдүүлэх

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд:

2.1.1 Тоосжилт үүсэж буй түүхий эд буулгах талбай болон, блок бутлуур, хогийн цэгийн хэсэгт салхины хүчийг сааруулж, орчинд тоосжилт тархахаас сэргийлэн түүхий эд буулгах талбайд 130 метр урттай, 7 метр өндөртэй, бутлуур, хогийн цэгийн хэсэгт 7 метрийн өндөртэй 158 метр урттай бетонон суурьтай салхины хаалт хийсэн.


Мөн энэ жил бид 19.600 м2 буюу 1.96 га /нийт талбайн 17.8 %/ хатуу хучилттай болгож агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаа.



Зураг:11 Хогийн цэг болон блок бутлуурын хэсгийн салхины хаалт



Зураг:12 Түүхий эд буулгах талбайн битүүмжлэл





Зураг:13 Талбайн цутгалтын явц

2.1.2 Агаарын чанарын мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлын хүрээнд: БОННУ-нд заагдсаны дагуу 4 цэгт улирал тутам Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгүүлсэн. Үүнд :

1. ЕВ-А-1 (Түүхий эд буулгах талбай)
2. ЕВ-А-2 (Хогийн цэг, ачилтын талбай)
3. ЕВ-А-3 (Бутлуур тээрмийн хэсэг)
4. ЕВ-А-4 (Уурын зуух орчим)

Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн



Дээрх хэмжилтийн дүнгээс үзэхэд агаар бохирдуулагч бодисын хэмжээ Монгол улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016 болон Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,

эрүүл ахуй, ажлын байрны орчин MNS 4990:2010 , Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйншуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага стандартуудыг хангаж, бохирдуулагч бодисын хэмжээ хүлцэх хэмжээнээс бага байна.

2.1.3 Агаарын чанарын мониторингийг өөрийн багажаар хийх ажлын хүрээнд:

Үйлдвэрийн агаарын чанарын хэмжилтийг батлагдсан хуваарийн дагуу PCE-EM882, PCE-RCM 10 багажуудаар 12 цэгт 5 минутын давтамжтай хийж гүйцэтгэсэн.

PCE-EM882 багажаар гэрэл, температур, чийг, дуу чимээ, **PCE-RCM 10** багажаар Агаарын тоос /PM 2.5, PM 10/ хэмжилтийг хийж Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS:4585:2016, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэнд ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэнд шуугианы норм, Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 стандартуудтай харьцуулж тодорхойлов.

Хүснэгт:7 Дотоодын багажаар хийсэн хэмжилтийн дүн

№	Сорьц авсан цэг	Тодорхойлсон утгууд											
		Дуу чимээ /db/	Стандарт хэмжээ	Температур /T /	Стандарт хэмжээ	Чийгшил /RH/	Стандарт хэмжээ	Гэрэл /LUX/	Стандарт хэмжээ	PM2.5	Стандарт хэмжээ	PM10	Стандарт хэмжээ
1	Түүхий эд буулгах талбай	65	85	2.4	-	30.6	30-60	1557	-	5	50-25	10	100-50
2	Шохойн тээрэм	84.5	85	6.4	18-22	30	30-60	469	150-300	29-32	50-25	92.8	100-50
3	Бөмбөлөгт тээрэм	82.1-86.5	85	17.3	18-22	35.8	30-60	240	150-300	37-48	50-25	90-94	100-50
4	Цамхаг орчим	78-80.3	85	17.5	18-22	41.3	30-60	144.5	50-150	45-69	50-25	60-95	100-50
5	Уурын зуух	80	85	11	18-22	29	30-60	80	50-150	13	50-25	65	100-50
6	Автоклавын хэсэг	70.5-76.5	85	22.2-24	18-22	69.3	30-60	50	50-150	39-46	50-25	40	100-50
7	Хөөлгөх хэсэг дотор	60-70	85	33.4	18-22	53	30-60	130.5	50-150	45-50	50-25	98-100	100-50
8	Блокны уур	68-75	85	13.5	18-22	75.6	30-60	128	50-150	100		56-85	100-50
9	Үйлдвэрийн гадна талбай орчин	45-50	60	11	18-22	30.2	30-60	1600	-	7	50-25	12	100-50
10	Оффис	48.8-50	60	19.3	18-22	32.3	30-60	240	150-300	12	50-25	25	100-50
11	Гал тогоо	58-62	60	17-18	18-22	34.5	30-60	132	150-300	133	50-25	280	100-50
12	Лаборатори	56-58.3	60	18.2	18-22	41	30-60	150	150-300	18	50-25	37	100-50

Дээрх хэмжилтийн дүнгээс үзэхэд агаар бохирдуулагч бодисын хэмжээ Монгол улсын стандарт болон олон улсын стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээд байна.

2.2 ГАЗРЫН ГАДАРГА ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

2023 онд үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

2.2.1 Бүх нийтээр **мод тарих өдөр** болон "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монголын алт МАК Төв оффисын ажилчид МАК Евроблок, МАК Евровиндоор, агааржуулалтын хоолойн үйлдвэрүүдийн ажилчид хамтран үйлдвэрийн шалган нэвтрүүлэх байрны зүүн тал болон ,зүүн урд талбайд шар хуайс 300 ширхэг, Буйлс 80, Гүйлс 30, Боролзгоно 50, Монос 50, Улиас 10 ширхэг нийт 7 төрлийн 520 ширхэг мод бут тарьсан мөн үйлдвэрийн урд талбайн 2900 м² талбайд зүлгийн нөхөн тарилт хийсэн.

Зураг:14 Тарилтын үеийн зураг





Зураг: 15 Үйлдвэрийн зүүн урд талбай, ШНБ зүүн талын тарилт



Зураг:16 Улиас модны тарилт




Зураг 17 Хайлаас модны шилжүүлэн суулгалт болон боролзгонын ургалтын үе



Зураг:18 Зүлэгний нөхөн тарилт

2.2.2 Аюултай хог хаягдлын ашиглалтад хяналт тавьж, сайжруулалт хийж ажиллах ажлын хүрээнд

Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, устгах зорилгоор төрөлжүүлэн ангилан ялгах боломжтой түр хогийн цэгийг сайжруулахаар хогийн цэгт дээвэр болон эргэн тойрны бүх талбайг хатуу хучилттай болгох ажил хийгдсэн ба хаягдал тос хадгалах савыг стандартын дагуу газар дор суурилуулж хөрсний бохирдол болон нарны шууд тусгалаас хамгаалж хүрээлэн буй орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүсгэхээс урьдчилан сэргийлж ажилласан. Мөн бид хуулийн нийцлийг хангахаар хог хаягдлын тухай хуулийн 8.1.9-д заасны дагуу аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж Ү- дугаар авч аюултай хог хаягдал болон бусад хог хаягдлуудын хадгалалт ашиглалтад тогтмол хяналт тавьж, бүртгэл мэдээллийг сайжруулан гэрээний дагуу эрх бүхий байгууллагуудад нийлүүлэн ажиллаж байна.





Зураг:19 Хогийн цэгийн сайжруулалт



Зураг:20 Хогийн цэгийн эргэн тойрны талбайн цутгалтын явц

**ТӨВ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273290, 70272457
Цахим шуудан: tov.baijal@gmail.com
Цахим хаяг: baijal.to.gov.mn

2022.06.20 № 07/248
Талай 2022.06.13 ны № 23/187

МОНГОЛЫН АЛТ ХХК-Д

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг Хог хаягдлын улсын эдээллийн сан (Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас)-д бүртгэв.

Бүртгэлийн дугаар: Y-001785

ДАРГА  Ж. ДАШ-ЯЙЧИЛ

412300000244

My com. D disc A5 тоот /2023/

Зураг:21 Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар



Зураг:22 Тос хадгалах савыг газар дор суурилуулах явц

Мөн хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд дахин боловсруулах боломжтой хог хаягдлуудыг ангилан ялдгаж, цуглуулж хуванцар сав 297 кг, аккумулятор 84 кг, ахуйн хэрэглээнээс гарч буй хаягдал шил 16 ширхгийг гэрээний дагуу Төвшин сайхан төвд тушааж эдийн засгийн эргэлтэд оруулсан.

[illegible]

Зураг:23 Дахивар хог хаягдлыг тушаах явц

Хог хаягдлын тухай хууль, дүрэм, журам, компани хог хаягдлын менежментийн журмыг үндэслэн үйлдвэр, уулын хэсэгт нийтээр дагаж мөрдөх **Хог хаягдлын менежментийн журам**, Аюултай хог хаягдал алдагдсан тохиолдолд авах арга хэмжээний журмыг боловсруулж батлуулан мөрдлөг болгон хог хаягдлын менежментийг сайжруулан ажиллаж байна.

УҮЛДЫҮЭРИЙН ДАРГА

БАТБАЯН ОЮУН
2023 оны ____ дүгээр ____ сар

УЛААНБААТАР

МАК
МАК БИРЭГ

"МАК КИРО КЛОУ" УҮЛДЭВРИЙН
ХӨГ ХАГАДГАЙН МЭНЭЭЖЭЭНИЙН ЖУРАМ

Бүтэнтэй бичигтэй мэд. МЭҮЭ 820-01

Хуульчдын дугаар: 1

Хуульчдын өгсөн: 2023 оны 08 дүгээр 08

Хяруулж өгсөн МЭҮЭ, Дотоодын мэд. тайл баримтууд
Журамд өргөмжлөх баримтууд:

Уугур	Агийн утгамаг	Өсөөг өгөр	Тайлбар
Хамттай	Бүтэнтэй тайлбар	Б. Хуульчид	
Тамгатай	Уугурчтай тайлбар	Т. Хуульчид	
Тамгатай	ХААГААГАЖ хэргийн дэргэ	Д. Дотоодын мэд.	
Тамгатай	Ам хуульчтай тайлбар	Д. Мэргэжлээр	
Тамгатай	Төмөрлөгчтэй хэргийн дэргэ	Б. Хуульчид	
Тамгатай	Зөвлөхтэй хэргийн дэргэ	Б. Хуульчид	
Боловсруулсан	Байнгын орлогын баримтууд	Б. Дотоодын мэд.	

Нийт хуудан: 18

Хуульчдын өгсөн: 2023. 08. 08

Уугурчтай баримт
2023 он

БАТБОВ
Батбаяр Д.А.АМАНДОРЖИЙ
2023 он - II улир - 5 саяр

ЛМАК
LAWYER MONGOLIAN ASSOCIATION

"ЛМАК ЕВРО КЛУБ" ҮЙЛЭЭРИЙН
АНУУЛТАЙ МЭГ ХАМТ АЖ АХАЙН АН ТӨХӨӨЛӨӨЛИЙН
АХАА АТГА ХАМТЭЙН БҮГДЭМ

Баруун Төвийн аймаг МНУ 60-02
Хуульчидын дугуйр 1
Хуульчидын өмнө 2022 оны 09 сарын 20

Хянангараж: МНУ-Дүнэмтэй оны нийт амжилтуу
Жуурын сөрөгтэй хэргүүдэд

Үүрэг	Ахуйн тэмдэг	Өмнө тэр	Гарын үсэг
Хуульчид	Хуульчидын ажиллагаа	Б. Цэцэгэл	
Хуульчид	ХАА-ВАЙТ-ХЭМТЭЙН АЖ АХАЙН	Д. Доржпүрэв	
Хуульчид	Хуульчидын ажиллагаа	Б. Цэцэгэл	
Хуульчид	Аж ахуйн хуульчидын ажиллагаа	Д. Монголсайр	Д. 16
Хуульчид	Төрийн хуульчидын ажиллагаа	Б. Цэцэгэл	
Хуульчид	Төрийн хуульчидын ажиллагаа	Б. Цэцэгэл	
Хуульчид	Хуульчидын ажиллагаа	Б. Цэцэгэл	
Хуульчид	Хуульчидын ажиллагаа	Б. Цэцэгэл	


Ийнхүү хуульчидын ажиллагааг
Хуульчидын өмнө 2022 он 09 сарын 20

Хуульчидын өмнө 2022 он 09 сарын 20

Улаанбаатар хот
2023 он

Зураг:24 Батлагдсан журмууд

Дахин ашиглах боломжтой төмрийн хаягдлаар хогийн сав болон хуванцар преислэгч машин хийж хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулан ажиллаж байна.



Зураг:25 Хэсэг нэгжүүдэд байрлуулсан хогийн сав

Аюултай хог хаягдал болон бусад хог хаягдлын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу тогтмол бүртгэж, хяналт тавин, бүртгэлийг ERP системд оруулж ажиллаж байна. / **Бүртгэлийг хавсаргав./**

МАК EURO BLOCK				
Евро блок үйлдвэр				
Хог хаягдлын бүртгэл				
№	Хог хаягдлын нэр	Хэмжээ нэгж	Энэ сарын нийт тус хэмжээ	Давхи өдөр хэмжээ
1	Григидий бүлэг хог	кг	89	
2	Хөдөлгөөний хог	кг	22.5	
3	Цахилгаан хайгуурт ба цахилгаан хайгуур	кг	5,850	
4	Хөдөлгөөний хог, нүүрс	кг	46,890	
5	Төс хог	кг	32,573	
6	Ногооны хаягдал	кг	20.5	
7	Шил	кг	10.2	
8	Хуванцар сав /тусам сав/	кг		
9	Хаягдал тос, тослоготой материал	кг		
10	Хаягдал асфальт	ш		
11	Хаягдал тэмдэг	тонн		
12	Төмөр нүүр	ш		
13	Алслагч нүүр	ш		
14	Алслагч нүүр	ш		
15	Хаягдал дугуй тос	ш		
16	Хаягдал дугуй хөдөлгөөний	ш		
17	Шилэн сав	ш		
18	Шилэн /хөдөлгөөний хөдөлгөөний	ш		
19	Шилэн /200 г /	ш		
20	Цахилгаан хайгуурт ба цахилгаан хайгуур	ш	13,500	
21	Хуванцар сав /тусам сав/	кг	20.5	
22	Хуванцар сав	кг	4,900	
23	Хаягдал мод	тонн		


МАК EURO BLOCK				
Аюултай хог хаягдлын бүртгэл				
№	Хог хаягдлын нэр	Хэмжээ нэгж	Энэ сарын нийт тус хэмжээ	Хаягдлын байршил
1	Төс хайгуур	кг	100	
2	Төс хайгуурт материал	кг	5	
3	Хаягдал асфальт	ш	30	
4	Төс хайгуур	ш	8	1.5
5	Алслагч нүүр	ш	8	1.5
6	Алслагч нүүр	ш	8	1.5
7	Хаягдал дугуй тос	ш	4	1.5
8	Хаягдал дугуй хөдөлгөөний	ш	4	1.5
9	Шилэн /хөдөлгөөний хөдөлгөөний	ш		
10	Шилэн /200 г /	ш		

Зураг:26 Хэсэг нэгжүүдийн хог хаягдлын бүртгэл

Зураас	Тохирол	Менежмент	Худалдан авалт	Хүний нөөц	Байгаль орчин	Тайлан	МАК Эхр зүй	МАК Сэг	МАК МЕЦ	ДАШНЯМ Б [ХБҮ]
Хог хаягдал										
1-80 нийт 108										
#	Үйлдвэр, уурхай	Он сар	Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын төрөл	Хог хаягдлын хэмжээ /т/	Дахин ашигласан /т/	Бүртгэсэн			
1	Дэнжийн элс-1	2023/09	Дахин ашиглах	Поошиг / 200 литр /	0.02000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
2	Евро блок үйлдвэр	2023/09	Дахин ашиглах	Поошиг / 200 литр /	0.54000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
3	Евро блок үйлдвэр	2023/09	Дахин ашиглах боломжгүй	Ерөнхий булах хог	483.00000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
4	Евро блок үйлдвэр	2023/09	Аюултай	Аккумулятор	0.12000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
5	Дэнжийн элс-1	2023/09	Дахин ашиглах	Агаарын шүүр	0.01200	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
6	Евро блок үйлдвэр	2023/09	Ахуйн	Хоолны үлдэгдэл	0.14870	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
7	Евро блок үйлдвэр	2023/09	Дахин ашиглах	Поошиг /Хөнгөн цагаан/	0.73200	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
8	Дэнжийн элс-1	2023/09	Аюултай	Аккумулятор	12.00000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
9	Евро блок үйлдвэр	2023/09	Аюултай	Тосны шүүр	9.00000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
10	Евро блок үйлдвэр	2023/09	Дахин ашиглах	Агаарын шүүр	12.00000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
11	Евро блок үйлдвэр	2023/09	Дахин ашиглах	Хаягдал дугуй /Жижиг/	0.04000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
12	Евро блок үйлдвэр	2023/09	Дахин боловсруулах	Хаягдал тос, тослогсооны материал	0.10900	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
13	Дэнжийн элс-1	2023/09	Аюултай	Тосны шүүр	0.02000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
14	Дэнжийн элс-1	2023/09	Дахин ашиглах	Хаягдал дугуй /Том /	0.03000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
15	Евро блок үйлдвэр	2023/08	Дахин ашиглах	Поошиг /Хөнгөн цагаан/	1.44300	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
16	Евро блок үйлдвэр	2023/08	Аюултай	Аккумулятор	0.09000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
17	Евро блок үйлдвэр	2023/08	Дахин боловсруулах	Шилэн сав	0.02000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
18	Дэнжийн элс-1	2023/08	Дахин ашиглах боломжгүй	Ерөнхий булах хог	1.00000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
19	Евро блок үйлдвэр	2023/08	Ахуйн	Хоолны үлдэгдэл	0.12000	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			
20	Евро блок үйлдвэр	2023/08	Дахин ашиглах	Поошиг / 200 литр /	0.15200	0.00	ДАШНЯМ Б [ХБҮ]			

Зураг:27 ERP-Хог хаягдлын бүртгэл

Хог хаягдлаа цуглуулах төрөлийн хувьд:



Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдал болох хаягдал тос, масло, хөнгөн цагааны поошигийг аюултай хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөлтэй “Түмэн эгшиг” ХХК-тай байгуулсан “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний дагуу нийлүүлж байна. Бусад хог хаягдлыг Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу тухай бүр нь хогийн цэг рүү тээвэрлэж газрын гадарга хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна. /Гэрээг хавсаргав/

Байгаль орчин, усны ашигласны байдал
2023 оны 12 сарын 12-ны өдөр А/21 дүгээр
тусламж 1 дүгээр хавсаргал

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДАЛЫН ДАГАЛДАХ БҮЛЭГ
Дансмаа **Түмэн Эгшиг**
ХХК-ийн байршил, хөдөлмөрийн байршил, хөдөлмөрийн байршил

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Эхр зүй "ХХК"**
2. Аюултай хог хаягдал үүсгэгчийн байршил:
3. Аюултай хог хаягдал хугацааг өгсөн:
4. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
5. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Эхр зүй "ХХК"**
6. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
7. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Эхр зүй "ХХК"**
8. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Эхр зүй "ХХК"**
9. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Эхр зүй "ХХК"**
10. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Эхр зүй "ХХК"**



Зураг:28 Аюултай хог хаягдлын дагалдах хуудас, тээвэрлэлтийн явц

Ерөнхий булах хог Налайх Төхижилт үйлчилгээний газарлуу ачуулсан бүртгэл

Жил	Огноо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	Нийт
2023 он	2023-01 сар	0			52.4	14.4							38.4					56.7			15.5					15.1	17.2						209.6
	2023-02 сар	0	35.6						29.8		17.3		10.4	30.7			33.1			34.8					37.5	38.7	17						284.7
	2023-03 сар	0	57.5	18.9		36.5	36.4			29.8	43.2	19.2	21.3	11.9	20	56.7	4			20	19.7	40.9				37.5	38.7	17		43.1			509.5
	2023-04 сар	0		18.7	41.7	43.5				22			38.2	84.4			36.4			22.3		55.4			66.5	44.2			67.9				563.9
	2023-05 сар	13.6		18.9	38.6					18.7	38.6	18.4			36.6		20.3	21			53.8				19.4	22.7		37.9		19.9	41.6	31.1	450.7
	2023-06 сар		41.8	18.9		17.7	18.2	40.6			36.8		31.1	18.2		51.9	36.4			39	2.85		50.1	60.1	18.4	35.9							517.6
	2023-07 сар	72.8					13.8				73.8				25.1	36.4		14.6					40.7				21.4			58.4	17.4		374.1
	2023-08 сар		37.2		18.3				39.4	58.7		19.5		36.9	35.8	33	33.2		35.5	21.1		16.3		17.5	18.3		19.4		19.8	20.3	19	18.6	515
	2023-09 сар		20		19.8	18.3		97.8		60.6		21.1		19.8	16.5	20.2		19.3		18.1	37.5		18.1			39.3			19	19.1	19.1		483
	2023-10 сар																																
	2023-11 сар																																
	2023-12 сар																																
	Нийт	86.4	192	76.4	171	130	68.4	138	110	312	54.8	110	164	164	97.3	238	127	112	67.8	133	186	67.2	109	163	162	160	133	67.9	102	139	86.6	18.6	

Зураг:29 Налайх тохижилт үйлчилгээний газарт ачуулсан хог хаягдлын бүртгэл

2.2.3 Шалган нэвтрүүлэх байр болон үйлдвэрийн зүүн урд талбайд тарилт хийх:

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ажилчдын ажиллах таатай орчин нөхцөлийг нэмэгдүүлэхээр шалган нэвтрүүлэх байрны зүүн тал болон үйлдвэрийн зүүн урд талбайд 7 төрлийн 520 ширхэг мод бут тарьсан мөн үйлдвэрийн урд талын 2900 м² талбайд зүлгийн нөхөн тарилт хийсэн.



Зураг:30 Тарилтын явц

2.2.4 Хөрсний мониторинг хийх ажлын хүрээнд:

Үйлдвэр нь хүнд машин механизмын засвар, үйлчилгээ, тээврийн хэрэгслүүдээс асгаралт үүсэж газрын гадарга хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлэн засвар үйлчилгээг тогтмол зориулалтын талбайд хийж тос масло асгарахаас сэргийлэн зориулалтын сав тосож засвар үйлчилгээг хийж байна Хөрсөнд тос масло асгарсан тохиолдолд тухай бүр нь Аюултай хог хаягдал алдагдсан тохиолдолд авах арга хэмжээний журмын дагуу мэдээлэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж бохирдсон хөрс болон бусад материалыг аюултай хог хаягдал хадгалах талбай болон хөрс саармагжуулах талбайд хадгалж эзэмшил газрын хэмжээнд болон ойр орчимд бохирдол үүсэхээс сэргийлэн ажиллаж байна. Мөн үйлдвэрийн хог хаягдлыг түр хадгалах цэг болон эргэн тойрон, блок бутлуурын хэсгийн талбайг энэ онд бүрэн хатуу хучилттай болгож салхины хүчийг сааруулах хашаа, хаалт хийж түүхий эд буулгах болон хадгалах талбайн битүүмжлэлийг хийж газрын гадаргад үзүүлэх сөрөг нөөллийг бууруулан ажиллаа.



БОННУ-д заасан хуваарийн дагуу улирал тутам хогийн цэг болон бүтээгдэхүүн хадгалах талбайн зонхилох салхины дор, түүхий эд буулгах талбай, бохирын цооног орчим хүнд металлын бохирдол үүсэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор итгэмжлэгдсэн лаборатори болох Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор холбогдох стагдартуудын дагуу шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх хүнд металлын агууламж нь MNS5850:2008 стандартаас давсан үзүүлэлт байхгүй үйлдвэрийн хөрс хүнд металаар бохирдоогүй хэмээн үзэж байна./ *Шинжилгээний дүнг тайланд хавсаргав/.*

Хүснэгт: 8 Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Он	Цэгийн нэр	Sr	Cd	Pb	Cu	Zn	Cr
			ppm	ppm	ppm	ppm	ppm	ppm
1	2023.03.29	Хог хаягдлын цэг	414.3	0.005	21.9	29.4	29.4	78.7
	2023.06.29		309.8	0.4	22.1	29.7	60.5	0.005
2	2023.03.29	Түүхий эд буулгах талбай	364.8	0.005	20.3	28.9	44.4	12.6
	2023.06.29		301.9	0.005	19.0	27.3	77.00	0.005
3	2023.06.29	Бохирын цооног орчим	374,5	0,6	27,4	28,3	76,2	0,005
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/			800	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/			1000,0	10,0	500,0	400,0	500,0	600,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/			1800,0	20,0	1200,0	1500,0	1000,0	1000,0

2.2.5 Газрын гадарга хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд үйлдвэрийн талбайд ахуйн болон бусад хатуу шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байхад хяналт тавьж ажлын байрны үзлэг шалгалтыг долоо хоног бүр байгаль орчны мэргэжилтэн хяналт шалгалт хийж гарсан зөрчлийг баталгаажуулан арилгуулж ажиллаж байна.

						
Department: / Хэлтэс:		ХАБЭАБО хэсэг		Inspection team/шалгах баг:		Б. Дашиям
Inspection place / Шалгалт хийсэн газар:		Технологи		Date / Огноо: 2023.09.12		АБҮ № БО 012
Hazard Legend: Class A (Major-do Immediately) Class B (serious) Class C / D (minor) / Аюулмэдээ: А зэрэг (Үлэмж-хандаруйх) / В зэрэг (ноцтой) / С зэрэг дунд / D зэрэг						
Non-STANDARD CONDITIONS / PERFORMANCE / СТАНДАРТ БҮС НӨХЦӨЛ / ҮЙЛДЭЛ						
№	Аюулын зэрэг	Дутагдал, зөрчлийн зураг /Photo Incident	Аюул, гарах үр дагавар	Хариуцсан хүн / Responsible person	Арга хэмжээ авах, хугацаа	Гүйцэтгэл /фото зургаар /Refcrmance
1	C	 	ЦХҮ-ийн хогийн цэгийн талбайд түр хадгалж буй хөнгөн цагааны поонгийг эмх цэгцгүй эрүүл талбайд хадгалж хөрсөн дээр хөнгөн цагааны нунтаг асгарч орчны бохирдол үүсгэж хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөллийг бий болгож байна, цаашлаад гал түймэр гарч ажилтны амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол үүсэх эрсдэлтэй байна. Зөрчлийг арилгахын тулд: 1. Хөнгөн цагааны поонгийг эмх цэгцтэй хурааж асгаралт үүсэхгүй байх нөхцөлийг хангаж ажиллах 2. Асгарсан нунтгийг элсээр цэвэрлэж бохирдсон элсийг хөрс саврмагжуулах зориулалтын талбайд хадгалах	Ерөнхий технологич С. Лхагвасүрэн	2023.09.14	Зөрчлийг арилгасан зураг

						
			Цаашид дээрх зөрчлүүд гаргахгүй байхад анхаарч хяналт тавьж ажиллана уу.			
АЖЛЫН БАЙРНЫ ҮЗЛЭГ ХИЙСЭН: 						
АЖЛЫН БАЙРНЫ ҮЗЛЭГТЭЙ ТАНИЦАЖ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН: — Зөрчлийг арилгасан зургаар. 						
						


Зураг:31 Хяналт шалгалтын хуудас

2.3 УСНЫ ЧАНАР НӨӨЦӨД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.3.1 Гүний худгийн тоног төхөөрөмж эрүүл ахуйн хамгаалалтыг тогтмол шалгаж сайжруулалт хийх ажлын хүрээнд: Үйлдвэрийн технологийн ус болон унд ахуйн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн 12 га талбайгаас зүүн өмнөд хэсэгт байрлах зөвшөөрөлтэй 4 гүний худгаас хангаж байна.

Хүснэгт: 9 Худгийн мэдээлэл

№	Худгийн дугаар	Байршил	Гүн,м	Уст үе	Тогтсон түвшин, м	Ундар га л/с	Төвшин бууралт, м	Хатуулаг Рн
1	41090-12	47041' 41.2'' 107013' 21.8''	80.0	23-70	22.64	3	13.0	3.6 7.3
2	41090-13	47041' 30.2'' 107013' 26.5''	61.0	23-52.5	23.51	3	13.04	3.4 6.52
3	41090-14	47041' 24.1'' 107012' 58.2''	80.0	27-52	20.53	7.5	7.1	3.6 7.37
4	41090-15	47041' 32.7'' 107013' 13.3''	80.0	26.2-41.2	26.22	5	4.2	2.7 7.41



Зураг:32 Худгуудын байршил

Ээлжийн сан техникч өдөр, шөнийн ээлжид ажиллах ба ээлж хүлээлцэх бүрд гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтыг шалгаж сайжруулалтыг хийж ажиллаж байна.

2.3.2 Усны хэрэглээг өдөр бүрд батлагдсан загварын дагуу бүртгэж хяналт тавьж, тэмдэг тэмдэглэгээг сайжруулан ажиллаж байна.

Усны тоолуурын заалт										2023 оны Өвсөр									
	281060		39369		2647		75625		49778		160354		19128		0				
Өдөр	Ерөнхий тоолуур		Технологийн зуук		Халаалтын зуук		Зүсэх шугам		Цэвэрлэг		Биебэлэгт газар		Хаялга цонх		Унд, ахуй				
	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз	Тоолуурын заалт /МЗ/	Хонгийн харгалз					
8/1/2023	281545	485	39520	154	2653	6	75660	35	49847	69	160443	89	19175	47	85				
8/2/2023	281982	437	39688	168	2656	3	75708	48	49906	50	160546	103	19190	15	41				
8/3/2023	282152	170	39783	95	2658	2	75717	9	49907	1	160583	37	19193	3	23				
8/4/2023	282332	180	39881	98	2662	4	75721	4	49907	0	160625	42	19201	8	24				
8/5/2023	282702	370	40032	151	2669	7	75749	28	49960	53	160704	79	19213	12	40				
8/6/2023	283139	437	40214	182	2680	11	75810	61	50018	58	160801	97	19218	5	23				
8/7/2023	283614	475	40413	199	2691	11	75854	44	50090	72	160909	108	19222	4	37				
8/8/2023	283908	294	40579	157	2698	7	75878	24	50131	41	160931	22	19225	3	40				
8/9/2023	284121	213	40674	104	2710	12	75880	2	50160	29	160985	54	19229	4	8				
8/10/2023	284538	417	40807	133	2722	12	75922	42	50225	65	161083	98	19232	3	64				
8/11/2023	285078	538	41012	205	2733	11	75978	56	50306	81	161220	137	19235	3	45				
8/12/2023	285528	452	41190	178	2743	10	76025	47	50374	68	161315	95	19240	5	49				
8/13/2023	285981	453	41374	184	2753	10	76073	48	50443	69	161412	97	19246	8	39				
8/14/2023	286406	425	41535	161	2762	9	76117	44	50504	61	161505	93	19249	3	54				
8/15/2023	286819	413	41694	159	2771	9	76185	68	50569	65	161607	102	19252	3	7				
8/16/2023	287292	473	41878	184	2780	9	76200	15	50645	76	161708	101	19263	11	77				
8/17/2023	287710	418	42045	167	2788	8	76237	37	50711	66	161807	99	19266	3	38				
8/18/2023	288115	405	42208	163	2794	6	76275	38	50782	71	161886	79	19270	4	44				
8/19/2023	288532	417	42350	142	2798	4	76321	46	50857	75	161989	103	19273	3	44				
8/20/2023	288949	417	42521	171	2803	5	76364	43	50918	61	162060	71	19276	3	63				
8/21/2023	289406	457	42702	181	2808	5	76410	46	50994	76	162120	60	19278	2	87				
8/22/2023	289836	230	42827	125	2814	6	76427	17	51015	21	162199	79	19284	6	-24				
8/23/2023	289861	225	42910	83	2816	2	76450	23	51055	40	162290	91	19288	4	-18				
8/24/2023	290148	285	42993	83	2819	3	76475	25	51101	46	162383	93	19293	5	30				
8/25/2023	290636	490	43209	216	2828	9	76526	51	51164	63	162475	92	19297	4	55				
8/26/2023	291104	488	43407	198	2836	8	76572	46	51224	60	162568	93	19304	7	56				
8/27/2023	291511	407	43560	153	2845	9	76620	48	51283	59	162655	87	19308	4	47				
8/28/2023	291950	439	43740	180	2849	4	76659	39	51345	62	162750	95	19312	4	55				
8/29/2023	292383	433	43918	178	2856	7	76706	47	51417	72	162844	94	19316	4	31				
8/30/2023	292836	453	44097	179	2864	8	76747	41	51487	70	162935	91	19320	4	60				
8/31/2023	293336	502	44298	201	2869	5	76797	50	51570	83	163041	106	19323	3	54				
	12278		4932		222		1172		1792		2687		141		1278				
Үйлдвэрлэлд	10583																		
Унд ахуй	1278																		
Хаялга цонх	141																		
Усалгаа	220																		

Зураг:33 Усны хэрэглээний бүртгэл

2.3.3 Усны чанарын мониторинг хийх

- 3.1. Хэрэглэгч нь дараах эрхтэй:
3.1.1. Гэрээний дагуу бохир ус нийлүүлэх үйлчилгээ хийнэ.



- 3.1.2. Хангагч болон ажилтнуудын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, гомдлыг “Чандмань-Налайх” ОНӨААТҮГ-ын диспетчерийн 70233310, 89953310 утсаар болон байгууллагын удирдлагад мэдээлэх, гомдол гаргах;
- 3.1.3. Өөрийн эзэмшлийн бохир ус нийлүүлэх үйлчилгээтэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах;
- 3.1.4. Хэрэглэгч нь Налайх дүүрэг 5 дугаар хорооны цэвэрлэх байгууламжийн тогтоосон худагт бохирыг нийлүүлнэ.
- 3.1.5. Хэрэглэгч нь бохир ус хүлээн авах ажилтны заасан худагт бохирыг нийлүүлж, баримтжуулан баримт авна.
- 3.2. Хэрэглэгч нь дараах үүрэгтэй:
- 3.2.1. Хэрэглэгч нь бохир ус нийлүүлэх төлбөрийг тухай бүр төлнө. /Гэрээ байгуулагдахад урьдчилан 30 тн бохирын төлбөрийг төлнө/.
- 3.2.2. Хангагч байгууллагатай заасан хугацаанд гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 3.2.3. Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох бүрд гэрээнд тодотгол хийлгэх;
- 3.2.4. Хэрэглэгч нь бохир усыг заасан худагт хийх ба бохир ус нийлүүлэх стандарт “MNS.6561:2015”-д стандартын шаардлагад нийцсэн бохир усыг нийлүүлнэ. Химийн бодис агуулсан буюу усанд уусахгүй бүхэл биет агуулсан бохир ус нийлүүлэхийг хориглоно.

Дөрөв. Хангагчийн эрх, үүрэг

- 4.1. Хангагч нь дараах эрхтэй:
- 4.1.1. Хэрэглэгчийн бохир ус нийлүүлэх стандарт шаардлага талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх;
- 4.2. Хангагч нь дараах үүрэгтэй:
- 4.2.1. Хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр төлбөртэй үйлчилгээг үзүүлэх;
- 4.2.2. Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлөхийг шаардах;
- 4.2.3. Хангагч нь хэрэглэгчийн санал гомдлыг хүлээн авч, 24 цагийн дотор барагдуулна.
- 4.2.4. Хэрэглэгчийн захиалга болон дуудлагаар засвар үйлчилгээний ажлыг батлагдсан үнэ тарифаар хийнэ.
- 4.2.5. Ажилтны буруугаас хэрэглэгчийг илүү төлбөр төлүүлсэн, төлөх нөхцөл байдалд хүргэсэн бол алдааг залруулах, дараа сарын төлбөрт шилжүүлэх;
- 4.2.6. Хангагч нь өөрийн эзэмшлийн бохир усны шугам, худгийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, стандартын тагтай байлгана.
- 4.2.7. Хэрэглэгчээс ирүүлж буй бохир ус болон хаягдлыг бохир ус нийлүүлэх худагт саадгүй шахах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

Тав. Талуудын харилцан хүлээх үүрэг хариуцлага

- 5.1 Талууд Иргэний хууль, Усны тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлын тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1 Талуудын хооронд гарсан хэрэглээ, төлбөр тооцоотой холбогдсон маргаантай асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.2 Гэрээний үүргийн биелэлтгүй холбогдсон маргаантай асуудлыг харилцан эс зөвшөөрвөл хуулийн байгууллагаар шийдүүлнэ.


Долоо. Бусад зүйл

- 7.1 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж Хэрэглэгч 2 хувь, Хангагч 1 хувийг хадгална. Гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.
- 7.2 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцалж болох ба энэ тухай хангагчид 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 7.3 Гэрээг цуцлахдаа үйлчилгээний төлбөрөө бүрэн барагдуулсан байна.
- 7.4 Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг хоёр тал хамтран шийдвэрлэх ба тохиролцоогүй тохиолдолд Хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.
- 7.5 Үнэ тарифт өөрчлөлт орох бүрд хангагч энэ тухай хэрэглэгчдэд 30 хоногийн өмнө албан мэдэгдэл болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэх ба үнэ тарифын хэрэгжилт нь эрх бүхий байгууллагын тушаал шийдвэрт заасан хугацаанаас эхлэн мөрдөгдөнө.
- 7.6 Хэрэв Хэрэглэгч гэрээний 7.5-д заасны дагуу өөрчлөлт орсон үнэ тарифыг хүлээн зөвшөөрөөгүй бол албан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ талаар Хангагч байгууллагад мэдэгдэж энэхүү гэрээг дуусгавар болгоно.
- 7.7 Гэрээнд хоёр тал харилцан тохиролцож нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 7.8 Талууд жил бүр гэрээг дүгнэж, тооцоо нийлж, акт үйлдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гэрээний мэргэжилтэн

 /Д.Өнөрмаа/

Утас: 89022793

Хаяг: Налайх дүүрэг, 2 хороо,
Дамдины гудамж

ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Үйлдвэрийн дарга

 /Д.Бадамдамдин/

91911638.
Утас: 89073076

Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум
4 дүгээр зөрлөг

БАТЛАВ:

“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК
-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ НЭГЭЛМҮҮН



БАТЛАВ:

“ТҮМЭН-ЭГШИГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЧИНЗОРИГ



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 10 сарын 13-ний өдөр

№

964-1121

Улаанбаатар хот

Нэг талаас “Түмэн-Эгшиг” ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Одбаяр,

Нөгөө талаас “Монголын Алт” (МАК) ХХК /цаашид “Үүсгэгч” гэх/, түүнийг төлөөлж Хангамж, техник үйлчилгээний газрын Захирал Д.Нинжбадгар бид нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч түр хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Энэ гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Үүсгэгч гэдэгт “Монголын Алт” (МАК) ХХК болон дор дурдсан түүний охин болон хамаарал бүхий компанийг хамтад нь ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. “МАК Цемент” ХХК;
 - 1.3.2. “Хүрэн толгой коал майнинг” ХХК;
 - 1.3.3. “Эрдэнэс цагаан суварга” ХХК;
 - 1.3.4. “Тру ти ар си” ХХК.
- 1.4. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ хийсэн байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2021 оны 10 сарын 13-ны өдрөөс 2022 оны 10 сарын 13-ны өдрийг хүртэл 1 (нэг) жилийн хугацаатай байна.
- 3.2. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдлын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com и-мэйл хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.4. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.5. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний Хавсралт №1-т заасан төлбөр тооцооны тарифт үнээр тооцож аюултай хог хаягдлыг шилжүүлнэ.
- 3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед Үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрснөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.7. Хүлээн авагч нь Үүсгэгчийн ирүүлсэн аюултай хог хаягдлыг Хавсралт №1-т заасан тарифт үнээс 5 хувийн хөнгөлөлттэй үнээр устгана.
- 3.8. Үүсгэгч нь гэрээний 3.5, 3.6-д заасан төлбөрийг “Түмэн-Эгшиг” ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкны 499085408 тоот дансанд нэхэмжлэхийн дагуу төлнө. Үүнд:
 - 3.8.1. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийн 40 хувийг,
 - 3.8.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэн өгч дагалдах бичгийн 1 хувь буцан ирснээс хойш ажлыг 5 хоногийн дотор төлбөрийн үлдэгдлийг.
- 3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд Хавсралт №2-т заасан үнийн дагуу Тээвэрлэлтийн зохих төлбөрийг төлнө.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1 Үүсгэгч аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
 - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
 - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
 - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг Хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
 - 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч хариуцна.
 - 4.1.8 Үүсгэгч аюултай хог хаягдлаа Хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

- 4.2.1 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал Үүсгэгчийн төлөөлөгчид мэдэгдэж зохих арга хэмжээг авах үүрэгтэй.
- 4.2.2 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог Үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.5 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших Хүлээн авагчийн аюултай хог хаягдал устгах үйлдвэрт хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч хүлээн авна.
- 5.5. Хүлээн авагч нь үүсгэгчийн шилжүүлэн өгсөн аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хууль, болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”-ын шаардлагад нийцүүлэн хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах ажиллагааг хариуцан гүйцэтгэх бөгөөд түүнийг зөрчсөний улмаас үүссэн хариуцлагаас Үүсгэгчийг ангид байлгана.
- 5.6. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөс хойших аливаа асуудалд хариуцлаа хүлээхгүй болно.

ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.7.2-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.2-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хуулиар зохицуулна.

- 7.5. Үүсгэгч аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт I-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлснээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.6. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Талуудын аль нэг нь гэрээний 3.1-т заасан хугацаа дуусгавар болсны дараа Гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд Гэрээг дахин 1 жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 9.3. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.4. Энэхүү гэрээг Монгол хэл дээр долоон хувь үйлдэж, Үүсгэгч 6 хувь, Хүлээн авагч 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгчийг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

Хуульч Б.Жанчив

Хүлээн авагчийг төлөөлж:

Ерөнхий менежер Б.Одбаяр



964-1121

..... тоот гэрээний Хавсралт №1

**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ**

(тээврийн зардал багтаагүй үнэ болно)

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төг/ НӨАТ тооцоогүй дүн
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л,	тн	1	1150000
2	Химийн хуванцар торх / 100л/	ш	1	4800
3	Химийн хуванцар торх /200л/	ш	1	5600
4	Химийн хуванцар ИВС танк /1000л/	ш	1	20000
5	Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/	тн	1	1250000
6	Төмөр торх поошиг	ш	1	4200
7	Химийн бодисын шил,сав	кг	1	1500
8	Капель,Тигл шаазан сав	кг	1	1600
9	Химийн хаягдал шингэн уусмал 1литр	л	1	3500-4500
10	Хаягдал аккумулятор	ш	1	5000
11	Масло шүүр том оврын	ш	1	3800
12	Принтер хор	ш	1	2500
13	Хаягдал агаар шүүгч филтэр	ш	1	4000
14	Хаягдал лаг	тн	1	950000
15	Хаягдал цаас	кг		400
16	Хаягдал маск болон бээлий нийлэг материал	кг	1	1500
17	Хаягдал шингээгч даавуу химийн бодистой	кг	1	3500
18	Хаягдал төмөр материал болон бусад	кг	1	2500
19	Хаягдал лааз сав	ш	1	1100
20	Хаягдал батарей	кг	1	3500
21	Ашигласан масло тос	1 литр	1	800
22	Хөргөлтийн шингэн тосол	1 литр	1	1000
23	Галын хорны баллон том жигжиг/дунд	1ш	1	3500-4800

НА
ХК
Г

24	Бохирдсон хөрс тостой	тонн	1	1600000
25	Эмнэлгийн хаягдал	кг	1	5500
26	Хаягдал аккумулятор	кг	1	3500
27	Хаягдал Battery	кг	1	1800
28	Хаягдал дугуй /том/	ш	1	12000-25000
29	Хүчил ба шингэн хаягдал	л	1	4200
30	Азотын хүчил	г	1	4200
31	Аммиак	г	1	4200
32	Давсны хүчил	кг	1	3800
33	Хүхрийн хүчил	кг	1	3800
34	Цууны хүчил	кг	1	3800
35	Фосфорын хүчил	кг	1	3800
36	Хлорт натри	кг	1	4200
37	Техникийн сальфитка, Алчуур шингээгч даавуу	кг	1	3500
38	Натри	л	1	3500
39	Хуурай бодис	кг	1	4200

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Үүсгэгчийг төлөөлж:
ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.....

Хүлээн авагчийг төлөөлж:
Ерөнхий менежер Б.Одбаяр



11
2A

964-1121

..... тоот гэрээний Хавсралт №2

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ҮНЭ

№	Машины марк, даац	Засмал зам	Шороон зам	Тайлбар
1	Хүнд даац: 25-30 тн Машины марк:	1км/4800 төг	1км/4800 төг	Үүсгэгч аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачих зардал ороогүй буулгах зардал өрсөн үнэ болно.
2	Бага даац: 3 тн, 5 тн Машины марк:	1км/3500 төг	1км/3500 төг	

Тайлбар:


- Дээрх тээвэрлэлтийн хөлсөнд НӨАТ тооцоогүй үнэ бөгөөд тээвэрлэлтийн зардлыг 1 талд нь тооцсон үнэ болно.

1.1 НҮБ-ын 2010 оны аргачлал, Монгол Улсын химийн бодисын тухай хууль, Монгол Улсын химийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS 4978:2000 стандарт, аюултай ачаа тээвэрлэх хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр маршрутын дагуу хөдөлмөр аюулгүй ажиллагааг ханган тээвэрлэнэ.

1.2 Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж Аюултай хог хаягдлын савыг зохих журмын дагуу бүрэн сулласан байх, хоосон сав нь ЗГ-ын 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:**Үүсгэгчийг төлөөлж:**

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар


Хүлээн авагчийг төлөөлж:

Ерөнхий менежер Б.Одбаяр



964-1121

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№

Дагалдах бичгийн дугаар:

/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл: Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр:								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн: Овог нэр Албан тушаалтан Гарын үсэг: Огноо: 2021 он сар өдөр								
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл: 1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилал зэрэглэл	Савлагаа ны бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
				Дугаар	Төрөл			
1								
2								
3								
4								
4. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:								
6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :								
1. Овог нэр: Гарын үсэг: 2021 он сар өдөр								
7. Үл зөхицол:								
8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл: Аж ахуйн нэгжийн нэр: "Түмэн-Эгшиг" ХХК "Түмэн-Эгшиг" ХХК бүртгэлийн дугаар: 0000001 Аюултай хог хаягдлыг хүлээн авсан: Овог нэр : "Түмэн-Эгшиг" ХХК Албан тушаал Гарын үсэг/ тамга / Огноо 2021 он сар ... өдөр								



БАТЛАВ.

“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦЭЛМҮҮН -2

ХОГ ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 он 04 сар 20 өдөр

№

655-1123

Улаанбаатар хот

Нэг талаас: Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй “Төвшин сайхан мөнх” НҮТББ (цаашид “А тал” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн,

Нөгөө талаас: Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй “Монголын алт” (МАК) ХХК (цаашид “Б тал” гэх), түүнийг төлөөлж Хангамж техник үйлчилгээний газрын захирал Д.Нинжбадгар, бид нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Б тал болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах дахин боловсруулах боломжтой хаягдал (цаашид “дахивар нөөц” гэх)-г тогтмол хуримтлуулан А талд хүлээлгэн өгөхтэй холбоотой харилцаанд Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгон зохицуулахад оршино.
- 1.2. Талуудын эрх бүхий албан тушаалтан гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 1.3. Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.
Үүнд:
Хавсралт № 1-Үнийн задаргаа.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ХУГАЦАА

- 2.1. Энэхүү Гэрээний хүрээнд Б тал болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниуд нь өөрсдийн үйл ажиллагаанаас гарах дахин боловсруулах боломжтой хаягдал (цаашид “дахивар нөөц” гэх)-ийг хуримтлуулан А талд хүлээлгэн өгнө.
- 2.2. А тал Б талын охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах дахивар нөөцийг захиалгын дагуу тохиролцсон хугацаанд очиж авна.
- 2.3. Нийлүүлэгч болон түүний охин, хараат, компани мөн түүний хамаарал бүхий компани гэдэгт дараах компаниудыг ойлгоно. Үүнд:

№	Компани	Регистрийн дугаар
1	“Монголын Алт” (МАК) ХХК	2095025
2	“Хүрэн толгой коал майнинг” ХХК	2697947
3	“МАК Цемент” ХХК	5830974
4	“Эрдэнэс цагаан суварга” ХХК	5824826
5	“МАК Аранжин зэс”	5849187
6	“Тру ти ар си” ХХК	6610188

- 2.4. Нэг удаагийн ачилт нь 3-4 тонн хэмжээтэй байна.
- 2.4. Энэхүү гэрээг 2023 оны 07-р сарын 20-ний өдрөөс 2024 оны 07-р сарын 20-ний өдөр хүртэлх хугацаанд байгуулсан болно.
- 2.5. Гэрээг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

МОНГОЛЫН АЛТ

ГУРАВ. ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Б тал нь А талд тээврийн зардалд гэрээний 2.3-т заасан хэмжээгээр 50 км тутамд 150,000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийг төлнө. /Үйлдвэр уурхайгаас очиж ачиж тээвэрлэсэн тохиолдол/
- 3.2. А тал нь Б талын Улаанбаатар хот дахь борлуулалтын цэгүүд, засвар үйлчилгээний төвөөс дахивар нөөц авах тохиолдолд 3.1-т заасан тээврийн төлбөр тооцогдохгүй болно.
- 3.3. Б тал нь дахивар нөөцийг энэхүү гэрээний Хавсралт №1-т заасан үнээр тооцож А талд нийлүүлнэ.
- 3.4. Ачилт хийхээс өмнө Талууд хамтран дахивар нөөцийг жинлэн, хэмжээг акт үйлдэн баталгаажуулна.
- 3.5. Энэхүү гэрээний 3.4-д заасан акт нь гэрээний төлбөр төлөх баримт болно.
- 3.6. А тал нь гэрээний үнийг гэрээний Хавсралт №1-д заасан тарифын дагуу тооцон ачилт хийснээс хойш ажлын 5 хоногт багтаан Б талын нэхэмжлэхийг үндэслэн төлнө.
- 3.7. А талын төлөх төлбөрөөс энэхүү гэрээний 3.1-т заасан тээврийн зардлыг Б талын санаачилгаар тухай бүр хасаж тооцож болно.
- 3.8. Б талын дансны мэдээлэл: Голомт банкны 8140000114 тоот төгрөгийн данс.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 А талын эрх, үүрэг:

- 4.1.1. А тал нь Б талаас дахивар нөөцийг аливаа механик бохирдолгүй, ангилж, нийлүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.1.2. А тал нь Б талаас шаардлага хангаагүй дахивар нөөцийг хүлээн авахгүй байх эрхтэй.
- 4.1.3. А тал нь Б талаас гарах дахивар нөөцүүдийн төрөл, хэрхэн хураах, хадгалах тал дээр зааварчилгаа өгөх үүрэгтэй.
- 4.1.4. А тал нь Б талаас гарах дахивар нөөцийг төлөвлөсөн хугацаандаа тогтмол хүлээн авах үүрэгтэй.
- 4.1.5. А тал нь дахивар нөөцийг ачихдаа Б талын өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.1.6. А тал нь Б талын үйлдвэр уурхайн бүсэд өөрийн ажилчдын ХАБЭА-н шаардлагыг ханган ажиллуулах үүрэгтэй.
- 4.1.7. А тал нь гэрээний 4.1.6.-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс аливаа эрсдэл, хохирол учирсан тохиолдолд Б тал хариуцлага хүлээхгүй.
- 4.1.8. А тал нь Б талын бэлтгэсэн дахивар нөөцийг үнэн зөвөөр тооцоолон хүлээн авах үүрэгтэй.
- 4.1.9. А тал нь дахивар нөөцийг тогтсон хугацаандаа хүлээн авах боломжгүй тохиолдолд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
- 4.1.10. А тал нь Б талыг хог хаягдлаа авчирч хүлээлгэн өгөх боломжгүй үед Б талын хүсэлтийн дагуу очиж авах үүрэгтэй.

4.2 Б талын эрх, үүрэг:

- 4.2.1. Б тал нь А талаас гэрээгээр тохирсон төлбөрийг энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөхийг шаардах эрхтэй.
 - 4.2.2. Б тал нь дахивар нөөцийг А талаас өгсөн зааврын дагуу ямар нэг үлдэгдэлгүй, бохирдолгүй, ангилан бэлтгэн нийлүүлэх үүрэгтэй.
 - 4.2.3. Б тал нь А талд дахивар нөөцийг хүлээн авах, ачилт хийхтэй холбоотой үйл ажиллагааны зааварчилгааг өгөх үүрэгтэй.
 - 4.2.4. Б тал нь А талд өөрийн байгууллагаас гарах бүхий л дахивар нөөцийг өгөх үүрэгтэй.
- 4.3 Талууд гэрээний хэрэгжилт, гэрээний талаарх үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
 - 4.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Талууд харилцан шаардах эрхтэй.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа хохирол учруулсан бол учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Бодит хохирол гэдэгт хохирогч талд учирсан шууд хохирол болон түүний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн хариуцлагыг ойлгоно.
- 5.2 Гэрээнд зааснаас бусад асуудлаар Талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх.
- 5.3 А тал нь ажил үүргийн дагуу, Б тал болон түүний хараат мөн хамаарал бүхий компаниудын талаар олж мэдсэн аливаа мэдээ, мэдээллийг бусдад дамжуулахгүй, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэй. Энэ үүргээ зөрчсөнөөс үүссэн хохирлын А тал бүрэн хариуцна.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1 Давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, газар хөдлөлт, террорист үйлдэл, ажил хаялт г.м/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлдлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.
- 6.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ цахимаар буюу бичгээр мэдэгдэнэ.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1 Хамтын ажиллагааны удирдлагыг талууд гэрээг байгуулагдсан үеэс хамтран хэрэгжүүлэх ба ийнхүү хамтран хэрэгжүүлэхдээ тэгш эрхтэйгээр оролцоно.
- 7.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд бичгээр болон хавсралтаар оруулсан нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 7.3 Энэ гэрээнээс үүсэх аливаа маргааныг талууд аль болох эвлэрэх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба боломжгүй бол Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 7.4 Гэрээнд оролцогч аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд ямарваа нэг өөрчлөлт орсон ч гэрээнд тусгагдсан заалтууд хүчин төгөлдөр хэвээр хадгалагдана.
- 7.5 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд А тал 1 хувийг, Б тал 2 хувийг хадгалах ба хуулийн адил хүчинтэй байна.

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

А тал:

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
2-р хороо, сэлбэ 10-р гудамж, 91 тоот

Утас: 9668-5858, 8813-0083

Б тал:


Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн
Чөлөө, төв байр-44

Утас: 7575-9700

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


А талыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн


.....


Б талыг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.....


ЭЗГ-ын Ахлах хуульч, газрын захирлын
үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Жавхлан

.....


655-1123


тоот гэрээний хавсралт №1

Үнийн задаргаа

ДАХИВАР НӨӨЦ		ҮНЭ - 1кг/₮	
		Төв	Очиж авах
ЗЭС	Гялгар	17500	8750
	Бохир	16500	8250
ГУУЛЬ	Гууль	6500	3250
ХАЙЛШ	Хайлш	3800	1900
	Хөнгөн цагаан	3800	1900
Радиатор		6500	3250
ТУГАЛГА	Шинэ	1500	750
	Бохир	1000	500
АККУМЛЯТОР		500	250
Батерей		500	250
ТӨМӨР	Зузаан төмөр	200	100
	Нимгэн төмөр	200	100
	Ган	200	100
	Ширэм	200	100
БУСАД	Тоног төхөөрөмж	+	+
	Мотор, хроп	+	+
	Хаягдал машин - 90.000₮-1сая.₮		
	Кузов - 10.000₮-30.000₮		
ГЯЛГАР УУТ	Пакет /бүт.савлагаа/	1000	500
	Зөөлөн	500	250
ХУВАНЦАР	Ус, ундааны /PET/	350	175
	Ахуйн зөөлөн /HDPE/	400	200
	Авдар, подон /PP/	100	50
	Вакум цонхны /PVC/	300	150
	Хөөсөнцөр	-	-
Лааз		2000	650
ЦААС	Цагаан цаас	50	20
	Бор цаас	60	20


А талыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн

.....


Б талыг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.....


ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2021-12-21

Дугаар: 0002043

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: Монголын алт МАК ХХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар:

9011071054

Регистрийн дугаар:

2095025

Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 1-р хороо, 19 хороолол, чингисийн өргөн чөлөө, монголын алт
ххк-ийн төв байр 44 тоот

Утас: 455785

Дараах химийн хортой, аюултай бодис:

Ашиглах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг

2021.12.21-2024.12.31

хүртэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томъёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хөнгөн цагааны нунтаг	Aluminum powder	Al	7429-90-5			120 тн
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: Замын үүд

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга

Химийн хорт болон аюултай бодисын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

/ Д. ГАНБОЛД /

/ Ц. БАТЖАРГАЛ /



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230202229615

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харъяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	799,230.00 ₮
Үйлгээний огноо:	2023-06-28 16:56:28.0
Үйлгээний утга:	1230202229615;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230202229672

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харъяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	799,230.00 ₮
Үйлгээний огноо:	2023-09-27 16:39:00.0
Үйлгээний утга:	1230202229672;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230201486067

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Татвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Татварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харъяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	14,008.00 ₮
Үйлгээний огноо:	2023-02-28 18:06:38.0
Үйлгээний утга:	1230201486067;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Татварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230201475623

ГТД / Регистр:

47001003455007 / 2095025

Гатвар төлөгчийн нэр:

Монголын алт МАК

Гатварын төрөл:

01030731 - Газрын төлбөр-Дэд алба

Саръяалах татварын алба:

Төв / Сэргэлэн

Гөлсөн дүн:

241,195.00 ₮

Үйлгээний огноо:

2023-02-28 18:06:51.0

Үйлгээний утга:

1230201475623;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН
АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999

Гатварын данс:

Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943

Гөлөлтийн хэлбэр:

Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230202229573

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харъяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	799,230.00 ₮
Үйлгээний огноо:	2023-02-28 18:06:29.0
Үйлгээний утга:	1230202229573;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230201239573

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Саръяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	414,420.00 ₮
Үйлгээний огноо:	2023-03-31 16:54:51.0
Үйлгээний утга:	1230201239573;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230201448190

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Саръяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	280,160.00 ₮
Үйлгээний огноо:	2023-03-31 16:54:56.0
Үйлгээний утга:	1230201448190;47001003455007;2095025;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Гөлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230201336080

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Саръяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	219,844.00 ₮
Үйлгээний огноо:	2023-03-31 16:55:07.0
Үйлгээний утга:	1230201336080;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1230201301852

ГТД / Регистр:	47001003455007 / 2095025
Гатвар төлөгчийн нэр:	Монголын алт МАК
Гатварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харъяалах татварын алба:	Төв / Сэргэлэн
Төлсөн дүн:	168,192.00 ₮
Үйлгээний огноо:	2023-03-31 16:55:02.0
Үйлгээний утга:	1230201301852;47001003455007;2095025;;47001003455007;99999999;8140000114;МОНГОЛЫН АЛТ МАК ХХК;Golomtbank-Online;99999999
Гатварын данс:	Тө.Сэ Газрын төлбөр - 100141700943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк

